

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2026/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3-4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
2.1 Аудит хийсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5-6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6-8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9-12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
3.1 Залруулга	12
3.2 Албан шаардлага	12
3.3 Зөвлөмж	14
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22-25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.25 № 346
танай _____ -ны № _____ -г

ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ЦЭВЭЭНРАВДАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дээд шатны төсөвт төвлөрүүлэх 59,060.1 сая төгрөгийн төсвийн орлогыг төвлөрүүлээгүй, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтад нийцээгүй 40.9 сая төгрөг зарцуулсан, хөтөлбөр, арга хэмжээний зардлаас нийт 1,036.8 сая төгрөгийн хуульд нийцээгүй санхүүжилт олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 5/02 тогтоолоор сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зардалд 105,876.3 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 59,496.2 сая төгрөг зарцуулсан байна.

4626050541

F:\2. Бичиг хэрэг\3026\он\СТА-ы дүгнэлт\Төсөл Док

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн орлогын төлөвлөгөөг 364,802.3 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 21,333.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 6/01 дугаар тогтоолоор Ханбогд сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 86.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,029,241.5	214,632,291.6
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	93,484,078.1	115,639,097.4
3	1.1.3 АВЛАГА	734,996.9	524,155.9
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	42,590	0.0
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	1,712,611.7	5,392,462.7
6	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	50,054,964.8	93,076,575.6
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	75,019,038.4	133,360,798
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	75,019,038.4	133,360,798
9	1.2.2.02 Биет хөрөнгө	68,810,402.6	127,151,298.5
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	6,208,635.9	6,209,499.5
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	221,048,280	347,993,089.6
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,884,485.4	12,515,751.5
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,645,160.7	2,057,189.5
14	2.1.1.03 Өглөг	1,354,516.4	2,057,189.5
15	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	290,644.3	0.0
16	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,239,324.8	10,458,562
17	2.1.2.02 Урт хугацаат зээл	11,239,324.8	10,458,562
18	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	208,163,794.5	335,477,338.1
19	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	208,163,794.5	335,477,338.1
20	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	4,728,347.4	4,728,347.4
21	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/	5,390,350	4,643,653.6
22	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	0.0	2,350,530
23	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	197,433,037.3	323,142,747.2
24	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	612,059.8	612,059.8
25	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	221,048,280	347,993,089.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	314,123,807	424,135,179.3
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	289,076,032.1	384,490,021.2
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	107,330,845	146,641,147.5
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	107,680,845	146,925,958.8

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-350,000	-284,811.3
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	176,764,896.9	232,681,096.2
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	4,980,290.2	5,167,777.5
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,386,784.5	39,645,158.1
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	510,117.2
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,660,990.4	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	220,897,037.8	298,442,877.9
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	220,897,037.8	298,442,877.9
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,911,058.8	19,615,843.9
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,053,448.6	1,331,953.6
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,561.7	183,972.3
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,815,138.8	1,687,347.1
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	7,689,696.8	5,454,115.7
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	75,948.9	60,098.2
19	1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	27,040	14,960
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,633,090.5	8,069,861.5
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	3,483,133.6	2,813,535.5
22	1.1.2.01.3 ТАТААС	30,000	30,000
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	198,955,979.1	278,797,034
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	93,226,769.1	125,692,301.4
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	127,225.1	345.3
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-127,225.1	-345.3
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	93,099,544	125,691,956

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	303,399,395.8	398,752,036
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	289,076,032.1	384,490,021.2
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	107,330,845	146,641,147.5
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-350,000	-284,811.3
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	176,764,896.9	232,681,096.2
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	4,980,290.2	5,167,777.5
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,027,184.1	1,174,896.4

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	3,895,352.4	3,912,619.3
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	57,753.7	80,261.9
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,665,073.3	14,262,014.8
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	9,665,073.3	8,880,693.3
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	510,117.2
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	4,871,204.3
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,658,290.4	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	216,982,409.5	298,395,094.2
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	216,982,409.5	298,395,094.2
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,031,380.5	17,110,774.4
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,460,865.6	4,283,230.4
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	516,462.3	183,950.4
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,283,999.3	2,331,874.9
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	2,001,696.9	2,851,213.2
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	78,900.6	60,098.2
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	27,040	14,960
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,106,232.3	6,994,136
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	556,183.4	391,311.3
26	1.1.1.2.01.3 ТАТААС	30,000	30,000
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	202,921,029.1	281,254,319.8
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	86,416,986.3	100,356,941.8
29	1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,544.7	5,108.1
30	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	59,973,562.1	78,207,030.6
31	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,973,562.1	78,207,030.6
32	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	59,973,562.1	78,207,030.6
33	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-59,968,017.4	-78,201,922.5
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	26,448,968.8	22,155,019.3
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,035,109.3	93,484,078.1
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	93,484,078.1	115,639,097.4

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,342,747.3		114,342,747.3
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	721,503.2		721,503.2
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	115,064,250.5		115,064,250.5
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	93,099,544		93,099,544
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,163,794.5		208,163,794.5
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,163,794.5		208,163,794.5
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	18,759.2		18,759.2
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,182,553.8		208,182,553.8
9	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	15,350		15,350
10	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	1,587,478.3		1,587,478.3
11	1.7 Тайлант үеийн үр дүн	125,691,956		125,691,956
12	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	335,477,338.1		335,477,338.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	369,723,487.6	391,087,079.8
2	3.1.01.1.1 Татварын орлого	363,236,678	384,490,021.2
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	144,294,229.9	146,641,147.5
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	144,579,041.2	146,925,958.8
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	142,627,241.2	142,941,778.4
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	100,000	152,004.4
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	391,800	236,188.8
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	60,000	176,232
9	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	1,400,000	3,419,755.2
10	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-284,811.3	-284,811.3

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

11	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-284,811.3	-284,811.3
12	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	213,761,448.1	232,681,096.2
13	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	213,676,569.4	232,588,708
14	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	5,000	5,970
15	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	79,878.7	86,418.2
16	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	5,181,000	5,167,777.5
17	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,185,000	1,174,896.4
18	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгийн хураамж	140,000	208,218.6
19	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000,000	942,667.8
20	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	45,000	24,010
21	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	3,900,000	3,912,619.3
22	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	3,900,000	3,912,619.3
23	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	96,000	80,261.9
24	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	96,000	55,070.1
25	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.0	25,191.8
26	3.1.01.1.2 Татварын бус орлого	6,486,809.6	6,597,058.6
27	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	1,615,605.3	1,725,854.3
28	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	1,500,000	1,551,668.6
29	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого / туслах/	113,500	174,185.8
30	3.1.01.1.2.1.7 Газрын тосны орлого	2,105.3	0.0
31	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	4,871,204.3	4,871,204.3
32	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,871,204.3	4,871,204.3
33	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,984,704.3	369,248,553
34	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	-100,891,631.3	291,202,046
35	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,093,027.6	10,242,953.8
36	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,412,981.7	1,187,653.5
37	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	648,852.8	486,243.6
38	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	714,777.6	672,846.1
39	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	8,100	0.0
40	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	41,251.3	28,563.7
41	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,622.7	167,092.4
42	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	120,103.5	118,331
43	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	14,129.8	11,963.1

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

44	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	7,064.9	6,297.7
45	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	7,064.9	5,981.7
46	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	28,259.6	24,518.8
47	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,893,531.9	1,687,347.1
48	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	564,947.3	363,840.6
49	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	2,102,195.9	1,258,333.9
50	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	226,388.7	65,172.6
51	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,464,213.3	1,373,069.8
52	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	11,100	7,942.3
53	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	110,120	88,810
54	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,660	20,415.8
55	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,301,333.3	1,245,907.2
56	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000	9,994.5
57	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	3,200	0.0
58	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,200	0.0
59	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	104,659.8	68,097.8
60	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	8,000	7,999.6
61	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	96,659.8	60,098.2
62	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	24,632.5	13,940
63	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	24,632.5	13,940
64	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,613,937.4	5,662,599.2
65	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,613,937.4	5,662,599.2
66	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	399,248.3	83,154.1
67	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	309,748.3	52,148.6
68	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	89,500	31,005.5
69	3.1.01.2.1.3 ТАТААС	30,000	30,000
70	3.1.01.2.1.3.2 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30,000	30,000
71	3.1.01.2.1.3.2.01 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30,000	30,000
72	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-114,014,658.9	280,929,092.2
73	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-114,112,042.7	280,866,567.6
74	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	341,802,542.5	281,157,611.2
75	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-455,914,585.2	-291,043.6
76	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	97,383.8	62,524.6

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

77	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,150	50,334
78	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,542	10,542
79	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,691.8	1,648.6
80	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,876,335.6	78,046,507
81	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	105,876,335.6	78,046,507
82	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	364,738,783.3	21,838,526.8
83	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-364,738,783.3	-21,838,526.8
84	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-364,738,783.3	-21,838,526.8
85	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	91,175,801.9
86	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	112,723,285.1
87	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	85	85
88	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	7	7
89	6.1.01 Төсвийн байгууллага	7	7
90	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	39
91	6.2.01 Удирдах ажилтан	9	9
92	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	25	25
93	6.2.03 Үйлчлэх ажилтан	4	4
94	6.2.04 Гэрээт ажилтан	1	1
95	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39	39
96	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18	18
97	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12
98	6.5.10 Гэрээт ажилтан	1	1
99	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	510,117.2
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	510,117.2
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	510,117.2
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	510,117.2
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	510,117.2
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	242,362.6
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	267,754.6
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,933.2
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	475,933.2

210	1.1.1.2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,933.2
2101	1.1.1.2.1.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	144,300.1
210104	1.1.1.2.1.1.1.4	Урамшуулал	144,300.1
2102	1.1.1.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,858.0
210201	1.1.1.2.1.1.2.1	Тэтгэврийн даатгал	11,094.4
210202	1.1.1.2.1.1.2.2	Тэтгэмжийн даатгал	1,272.0
210203	1.1.1.2.1.1.2.3	ҮОМШӨ-ний даатгал	2,409.2
210204	1.1.1.2.1.1.2.4	Ажилгүйдлийн даатгал	653.6
210205	1.1.1.2.1.1.2.5	Эрүүл мэндийн даатгал	1,428.7
2104	1.1.1.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	5,597.8
210402	1.1.1.2.1.1.4.2	Тээвэр, шатахуун	5,597.8
2107	1.1.1.2.1.1.7	Томилолт, зочны зардал	1,020.0
210702	1.1.1.2.1.1.7.2	Дотоод албан томилолт	1,020.0
2109	1.1.1.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	308,157.2
210901	1.1.1.2.1.1.9.1	Бараа үйлчилгээний бусад зардал	308,157.2
4	1.1.1	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	34,184.0
5	1.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(34,184.0)
6	1	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(34,184.0)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,652.1 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 6,652.1 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн дүнг 2,444.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүнг 2,012.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн өр төлбөр цэвэр хөрөнгө, өмчийн дүнг 2,194.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь УСНББОУС-1, "Санхүүгийн тайлангийн толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 60,137.8 сая төгрөгийн 13 зөрчил² илэрснээс 60,137.8 сая төгрөгийн 12 зөрчилд арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгч ажиллалаа.

3.1 АЛБАН ШААРДЛАГА:

Илрүүлэлт-1: Сумын төсвийн орлого 21,332.9 сая төгрөгөөр давж биелсэн байхад аймгийн төсөвт 336,560.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 277,500.3 сая төгрөг төвлөрүүлж 59,060.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна

Илрүүлэлт-2: Анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар нийт 105.5 сая төгрөгийн 7 ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-3: Хөтөлбөр, арга хэмжээнээс төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн 619.3 сая төгрөгийн 11 ажилд хувь хүн болон компанитай гэрээ шууд байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 35 дугаар зүйл "Гэрээ шууд байгуулах арга" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-4: "Цэгцтэй гудамж ажлыг зохион байгуулах" арга хэмжээнээс төсвийн тооцоолол, үнэлгээгүйгээр 2 иргэнд 19.8 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-5: "Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх, Чадварлаг мэргэжилтнүүдийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд орон нутгаас дэмжиж ажиллах" хөтөлбөрөөс 63.0 сая төгрөгийн гэрээг "Ханбогд хөгжлийн төлөө" НҮТББ-тай байгуулсан байна. Тус НҮТББ-ийн үйл ажиллагааны чиглэл "Иргэд, аж ахуй нэгжид санхүү, татварын талаарх болон төсөл хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх" байгаа нь гүйцэтгэх арга хэмжээтэй таарахгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Хуульд өөрөөр заагаагүй бол компани нь зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-6: Сумын түүх соёл, нутгийн зөвлөл, хөгжлийг сурталчлах, сумын онцлогийг илэрхийлсэн бэлэг дурсгал, цагаан сарын баяр, сумын 101 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах бусад байгууллагын ойн арга хэмжээг дэмжих, үндэсний ёс заншил уламжлалаа дэмжин хөгжүүлэх арга хэмжээний зардлаас 27.0 сая төгрөгийн ажлын төсвийг хуваан шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-7: "Төрийн албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх танхимын болон онлайн, сертификаттай сургалтад хамруулах, харилцаа хандлагыг сайжруулах нэгдсэн сургалт арга хэмжээг зохион байгуулах" арга хэмжээнээс 1.3 сая төгрөг, "Газар тариалан эрхлэлтийн туршилт судалгааг дэмжиж, хүнсний ногоо тариалах цар хүрээг нэмэгдүүлнэ" арга хэмжээнээс 42.6 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-8: Осолд орсон Сумын мал эмнэлгийн төвийн ланд 76 автомашины засварт 34.5 төгрөг, Цагдаагийн автомашины приус 41 засварт 15.0 төгрөгийг буруутай этгээдээс бус төсвийн хөрөнгөөр засварласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-9: Сум дахь гал түймэр унтраах аврах 66 дугаар ангийн ажлын байрны түрээсийн төлбөрт 30.0 сая төгрөгийг төлөвлөн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-10: Ойдов тойн ургийн баярын уулзалтын арга хэмжээнд зардалд 39.8 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-11: Төрийн албан хаагч, малчид, бизнес эрхлэгч, иргэдийг дотоод болон гадаад оронд туршлага судлуулах хөтөлбөрийн зорилтод нийцээгүй 3 захирамжаар нийт 39.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-12: Тайлант хугацаанд Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтад нийцээгүй 40.9 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1 "Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2 ЗӨВЛӨМЖ:

Илрүүлэлт-1: Сумын Засаг даргын захирамжаар малчин, төрийн албан хаагч, оюутан болон бусад иргэдэд жил бүр дэмжлэг үзүүлсэн боловч дэмжлэгт хамрагдсан иргэдийн нэгдсэн мэдээллийн сан үүсгээгүйгээс шалтгаалан өмнө нь энэ төрлийн тусламж, дэмжлэг авсан, гэр бүлийн гишүүн давхардаж байгаа эсэхэд хяналт хийгдээгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дэмжлэг авсан иргэдийн нэгдсэн мэдээллийн сантай болж давхардуулан олгож байгаа эсэхэд хяналт тавих.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АЛДААНЫ НЭГТГЭЛ

/сая төгрөгөөр/

АЛДААНЫ ТОВЧ УТГА	НИЙТ АЛДАА		МЭДЭЭЛЛИЙГ ТУСГАХГҮЙ ОРХИГДУУЛСАН		БУРУУ ТУСГАН ИЛЭРХИЙЛСЭН		ҮҮНЭЭС				ЗӨВЛӨМЖ	
							ЗАЛРУУЛСАН		ЗАЛРУУЛААГ ҮЙ			
	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН
Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн дүнг 2,444.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,	1	2,444.5			1	2,444.5	1	2,444.5				
Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүнг 2,012.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	2,012.8			1	2,012.8	1	2,012.8				
Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн өр төлбөр цэвэр хөрөнгө, өмчийн дүнг 2,194.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна	1	2,194.8			1	2,194.8	1	2,194.8				
ДҮН	3	6,652.1			3	6,652.1	3	6,652.1				

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/сая төгрөгөөр/

ЗӨРЧЛИЙН ТОВЧ УТГА	НИЙТ ЗӨРЧИЛ		ҮҮНЭЭС									
			ТӨЛБӨРИЙН АКТ		АЛБАН ШААРДЛАГА		ЗӨВЛӨМЖ		ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ АЛБАН ШААРДЛАГА		ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛСЭН АСУУДАЛ	
	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	А/Т/ТОО	ТОО	ДҮН
Сумын төсвийн орлого 21,332.9 сая төгрөгөөр давж биелсэн байхад аймгийн төсөвт 336,560.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 277,500.3 сая төгрөг төвлөрүүлж 59,060.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.	1	59,060.1			1	59,060.1						
Анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар нийт 105.5 сая төгрөгийн 7 ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.	1	105.5			1	105.5						
Хөтөлбөр, арга хэмжээнээс төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн 619.3 сая төгрөгийн 11 ажилд хувь хүн болон компанитай гэрээ шууд байгуулсан байна.	1	619.3			1	619.3						
"Цэгцтэй гудамж ажлыг зохион байгуулах" арга хэмжээнээс төсвийн тооцоолол, үнэлгээгүйгээр 2 иргэнд 19.8 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна	1	19.8			1	19.8						
"Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх, Чадварлаг мэргэжилтнүүдийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд орон нутгаас дэмжиж ажиллах" хөтөлбөрөөс 63.0 сая төгрөгийн гэрээг "Ханбогд хөгжлийн төлөө" НҮТББ-тай байгуулсан байна. Тус НҮТББ-ийн үйл ажиллагааны чиглэл "Иргэд, аж ахуй нэгжид санхүү, татварын талаарх болон төсөл хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх" байгаа нь гүйцэтгэх арга хэмжээтэй таарахгүй байна.	1	63.0			1	63.0						

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сумын түүх соёл, нутгийн зөвлөл, хөгжлийг сурталчлах, сумын онцлогийг илэрхийлсэн бэлэг дурсгал, цагаан сарын баяр, сумын 101 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах бусад байгууллагын ойн арга хэмжээг дэмжих, үндэсний ёс заншил уламжлалаа дэмжин хөгжүүлэх арга хэмжээний зардлаас 27.0 сая төгрөгийн ажлын төсвийг хуваан шууд гэрээ байгуулсан байна.	1	27.0			1	27.0						
"Төрийн албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх танхимын болон онлайн, сертификаттай сургалтад хамруулах, харилцаа хандлагыг сайжруулах нэгдсэн сургалт арга хэмжээг зохион байгуулах" арга хэмжээнээс 1.3 сая төгрөг, "Газар тариалан эрхлэлтийн туршилт судалгааг дэмжиж, хүнсний ногоо тариалах цар хүрээг нэмэгдүүлнэ" арга хэмжээнээс 42.6 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.	1	43.9			1	43.9						
Осолд орсон Сумын мал эмнэлгийн төвийн ланд 76 автомашины засварт 34.5 төгрөг, Цагдаагийн автомашины приус 41 засварт 15.0 төгрөгийг буруутай этгээдээс бус төсвийн хөрөнгөөр засварласан байна.	1	49.5			1	49.5						
Сум дахь гал түймэр унтраах аврах 66 дугаар ангийн ажлын байрны түрээсийн төлбөрт 30.0 сая төгрөгийг төлөвлөн зарцуулсан байна.	1	30.0			1	30.0						
Ойдов тойн ургийн баярын уулзалтын арга хэмжээнд зардалд 39.8 сая төгрөг зарцуулсан байна.	1	39.8			1	39.8						
Төрийн албан хаагч, малчид, бизнес эрхлэгч, иргэдийг дотоод болон гадаад оронд туршлага судлуулах хөтөлбөрийн зорилтод нийцээгүй 3 захирамжаар нийт 39.0 сая төгрөг зарцуулсан байна.	1	39.0			1	39.0						
Тайлант хугацаанд Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтад нийцээгүй 40.9 сая төгрөг зарцуулсан байна.	1	40.9			1	40.9						
Сумын Засаг даргын захирамжаар малчин, төрийн албан хаагч, оюутан болон бусад иргэдэд жил бүр дэмжлэг үзүүлсэн боловч дэмжлэгт хамрагдсан иргэдийн нэгдсэн мэдээллийн сан үүсгээгүйгээс шалтгаалан өмнө нь энэ төрлийн тусламж, дэмжлэг							1	-				

авсан, гэр бүлийн гишүүн давхардаж байгаа эсэхэд хяналт хийгдээгүй олгосон байна												
ДҮН	12	60,137.8			12	60,137.8	1	-				

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

/сая төгрөгөөр/

ЗӨРЧЛИЙН ТОВЧ УТГА	НИЙТ ЗӨРЧИЛ		ҮҮНЭЭС					
			ТӨЛБӨРИЙН АКТ		АЛБАН ШААРДЛАГА		ЗӨВЛӨМЖ	
	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН
ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ								
Шилэн дансны хуультай холбоотой зөрчил гараагүй байна.								
ДҮН								
БУСАД ХУУЛЬ, ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ								
Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил гараагүй байна.								
ДҮН								